



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар A/184

Ховд

Г Жуух бичгээр шагнах тухай Г

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Боловсролын салбарт олон жил үр бүтээлтэй хамт олноо манлайлан ажиллаж буй Ховд их сургуулийн Гадаад хэл соёлын сургуулийн тэнхимийн багш М.Алтансүвд, Ж.Ванчинхүү, Манхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн жижүүр М.Уранчимэг нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан М.Алтансүвд, Ж.Ванчинхүү, М.Уранчимэг нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг дээрх сургуулиудын захирал нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

